

## ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 23 дахь дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн “**Судалгаа**” хэсэгт Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний түүхэн хандлага, Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн дутагдаж буй хэрэгцээ, Нийгмийн халамжийн бодлогын үр дүнгийн судалгаа зэрэг эрдэм шинжилгээний ажлуудаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг танилцуулж байна.

“**Үзэл бодол**” хэсгээр 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Хүн ам ба хөгжлийн асуудлаархи Үндэсний дээд хэмжээний уулзалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Олон улсын бага хурлын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ахиулж, зорилго зорилтуудад хүрэхийн төлөөх ажлаа үргэлжлүүлэх амлалтыг дахин авч хэлэлцсэн Улаанбаатар хотын тунхаглалыг танилцуулж байна. Мөн Монгол Улсын хүн ам зүйн өөрчлөлт, чиг хандлага, судалгаа зөвлөх үйлчилгээг олон улсын стандартын дагуу гүйцэтгэх нөхцөл бүрдэж буй талаар эрдэмтдийн санаа бодол, байр суурийг илэрхийлсэн болно.

“**Сургалт**” хэсгээс “Өрхийн ам бүлийн бүтцийн засварлалт: Тэнцвэржүүлэх хэмжээс”-ийн талаар шинэ мэдлэг олж, оюуны цар хүрээгээ тэлээрэй.

Сэтгүүлийнхээ **English** хэсэгт Монголын хүүхдийн эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлс сэдэвт гүнзгийрүүлсэн шинжилгээний үр дүнг нийтэллээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яаманд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**